

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/239/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a> Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг Утас: 261885 Цахим хаяг: <a href="mailto:erdenetsetsegi@audit.gov.mn">erdenetsetsegi@audit.gov.mn</a> Аудитор: С.Билгүтэй Утас: 261628. Цахим хаяг: <a href="mailto:bilguteis@audit.gov.mn">bilguteis@audit.gov.mn</a> Эс Жи Эм Ди-Аудит ХХК-ийн захирал: Д.Насанжаргал Утас: 99996948 Цахим хаяг: <a href="mailto:nasaa@sgmd-audit.mn">nasaa@sgmd-audit.mn</a>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....</b>	<b>6</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	15
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....</b>	<b>16</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	16
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	17
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	18
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН.....</b>	<b>20</b>
4.1 Ерөнхий зүйл.....	20
4.2 Материаллаг байдал .....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	22
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>23</b>
5.1 Албан шаардлага.....	23
5.2 Зөвлөмж.....	24
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>26</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026. 02.25 № 06/417  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН  
ГАЛЕРЕЙН ЗАХИРАЛ  
М.ОТГОНЧИМЭГ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын уран зургийн галерейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 33,105.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Хувиараа үзэсгэлэн гаргаж байгаа зураачийн үзэсгэлэнд ирсэн хүмүүст зориулж катерингийн үйлчилгээний зардал 4,800.0 мянган төгрөгийг зарцуулж, төсвийг үрэлгэн зарцуулсан;
- Сан хөмрөгийн үзэсгэлэнгийн харуул хамгаалалтын зардалд 4,500.0 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийж, бүртгэлд тусгасан.
- Уран зургийн галлерейн салбар байгуулахад зориулж 14,560.0 мянган төгрөгийн үнэтэй 150 ширхэг жааз худалдан авсан, гэрээг байгууллагын нярав байгуулан бараа материалыг хүлээн авсан нь ажил үүргийн хувиарийн дагуу тавих хяналт сул, үр ашиггүй зардал гаргасан байх эрсдлийг бий болгож байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж 3 нэр төрлийн 1388 ширхэг 9,245.5 мянган төгрөгийн бараа материалыг нөөцлсөн бэлтгэн байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, Нягтлан

Z:\Yawsan\_Bichig\2026\0225 SAG-94.Docx

1526140835

бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монгол улсын түүх соёлын үнэт 18 бүтээлд орчин үеийн дижитал технологи болох AR технологийг тайлант хугацаанд нэвтрүүлэн ажилсан. Уг технологийг нэвтрүүлснээр дүрслэх урлагийн бүтээлийг хөдөлгөөнт сонирхолтой хэлбэрээр үзэхээс гадна виртуал хөтчийн тусламжтай англи, монгол хэл дээр мөн сонсголын бэрхшээлтэй иргэд дохионы хэлмэрчийн тусламжтай бүтээлийн тайлбарыг авах боломжтой болсон байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монголын уран зургийн галерей нь тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 10,000.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 194,805.3 мянган төгрөг, нийт 204,805.3 мянган төгрөгийг бүрдүүлж, 101,282.8 мянган төгрөгийг зарцуулж, 103,522.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

### **Бусад асуудал**

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартыг мөрдөж ажиллах үүрэг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>192,208,782.19</b>	<b>334,241,320.47</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>6,091,154.69</b>	<b>111,898,538.19</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	1,004,849.90
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>6,091,154.69</b>	<b>110,893,688.29</b>
3351	Байгууллагаас авах авлага	-	104,802,533.60
3352	Хувь хүмүүсээс авах авлага	6,091,154.69	6,091,154.69
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>186,117,627.50</b>	<b>222,342,782.28</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>24,176,831.01</b>	<b>22,330,131.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	24,176,831.01	22,330,131.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>161,940,796.49</b>	<b>200,012,651.28</b>
35410	Бичиг хэргийн материал	24,378,360.00	37,108,620.00
35420	Аж ахуйн материал	2,902,638.00	2,140,500.00
35450	Барилгын засварын материал	882,750.00	194,500.00
35470	Бусад хангамжийн материал	133,777,048.49	160,569,031.28
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>15,937,986,306.68</b>	<b>15,960,256,780.53</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>15,937,986,306.68</b>	<b>15,960,256,780.53</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>15,919,336,306.68</b>	<b>15,929,934,780.49</b>
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	195,801,134.42	261,540,934.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,118,973.29)	(92,550,391.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	277,890,195.00	303,390,195.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(66,896,060.45)	(106,105,967.94)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	15,561,360,444.00	15,561,360,444.00
39217	Ном	2,299,567.00	2,299,567.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>18,650,000.00</b>	<b>30,322,000.04</b>
39301	Програм хангамж	19,850,000.00	37,970,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,200,000.00)	(7,647,999.96)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>16,130,195,088.87</b>	<b>16,294,498,101.00</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	-	<b>202,535,573.60</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>202,535,573.60</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	-	<b>93,513,585.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	239,085.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	93,274,500.00
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	-	<b>109,021,988.60</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	-	27,821,988.60
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	81,200,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>16,130,195,088.87</b>	<b>16,091,962,527.40</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>16,130,195,088.87</b>	<b>16,091,962,527.40</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	693,724,428.90	693,724,428.90
51101	Өмч: - төрийн	693,724,428.90	693,724,428.90
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,183,025,591.97</b>	<b>1,144,793,030.50</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,183,025,591.97	1,183,025,591.97
51220	Тайлант үеийн үр дүн	-	(38,232,561.47)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	14,253,445,068.00	14,253,445,068.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>16,130,195,088.87</b>	<b>16,294,498,101.00</b>

Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,297,585,000.00</b>	<b>1,394,877,503.60</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>28,000,000.00</b>	<b>1,394,877,503.60</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>28,000,000.00</b>	<b>3,120,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	28,000,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	28,000,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	3,120,000.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>-</b>	<b>1,391,757,503.60</b>
1221	Хандив тусламж /дотоод/	-	1,391,757,503.60
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,185,672,200.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	1,185,672,200.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	206,085,303.60
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,000,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	196,085,303.60
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,269,585,000.00</b>	<b>-</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,004,142,900.00</b>	<b>-</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,004,142,900.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>265,442,100.00</b>	<b>-</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,900,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	216,542,100.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>1,170,997,692.30</b>	<b>1,433,110,065.07</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,170,997,692.30</b>	<b>1,433,110,065.07</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,094,245,321.56</b>	<b>1,281,547,662.92</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>515,679,712.79</b>	<b>590,638,602.03</b>
210101	Үндсэн цалин	297,896,599.99	315,196,525.79
210102	Нэмэгдэл	84,945,643.80	74,747,765.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	85,499,455.00	145,454,400.90
210104	Урамшуулал	47,338,014.00	55,239,910.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>64,183,942.87</b>	<b>74,831,872.52</b>
210201	Тэтгэврийн даатгал	43,556,742.87	52,887,565.78
210202	Тэтгэмжийн даатгал	5,156,800.00	4,809,721.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,578,400.00	2,849,174.28
210204	Ажилгүйдлийн даатгал	2,578,400.00	2,849,174.28
210205	Эрүүл мэндийн даатгал	10,313,600.00	11,436,236.53
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>155,025,600.00</b>	<b>287,280,000.00</b>
210304	Байрны түрээс	155,025,600.00	287,280,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>75,625,871.60</b>	<b>65,286,820.01</b>
210401	Бичиг хэрэг	42,535,016.00	29,048,852.00
210402	Тээвэр,шатахууны зардал	400,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,139,150.60	2,360,835.00

Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,551,705.00	33,877,133.01
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	-	<b>15,903,000.00</b>
210604	Урсгал засвар	-	15,903,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,950,000.00</b>	-
210702	Дотоод томилолтын зардал	4,950,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>213,726,442.17</b>	<b>123,097,042.21</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	203,516,342.17	115,563,142.21
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000,000.00	5,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,210,100.00	2,533,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>65,053,752.13</b>	<b>124,510,326.15</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	34,509,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,912,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	65,053,752.13	87,089,326.15
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>76,752,370.74</b>	<b>151,562,402.15</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>71,507,241.00</b>	<b>19,361,200.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,267,200.00	19,361,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	52,240,041.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,245,129.74</b>	<b>132,201,202.15</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	400,709.74	28,678,668.55
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	4,844,420.00	103,522,533.60
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>126,587,307.70</b>	<b>(38,232,561.47)</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>		
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	80,625.00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>80,625.00</b>	<b>-</b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>126,506,682.70</b>	<b>(38,232,561.47)</b>

Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО</b>	<b>1,270,765,000.00</b>	<b>1,390,477,503.60</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>1,390,477,503.60</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	<b>1,390,477,503.60</b>
1221	Хандив тусламжийн орлого (дотоод)	-	<b>1,390,477,503.60</b>
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	1,185,672,200.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	1,185,672,200.00
<b>12213</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>204,805,303.60</b>
122134	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,000,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	194,805,303.60
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,270,765,000.00</b>	-
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,004,142,900.00</b>	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,004,142,900.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>266,622,100.00</b>	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,900,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	217,722,100.00	-
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,270,765,000.00</b>	<b>1,390,477,503.60</b>
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>1,145,642,000.00</b>	<b>1,284,237,703.60</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,145,642,000.00</b>	<b>1,284,237,703.60</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,068,889,629.26</b>	<b>1,132,675,301.45</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>515,679,712.79</b>	<b>590,729,974.77</b>
210101	Үндсэн цалин	297,896,599.99	315,287,898.53
210102	Нэмэгдэл	84,945,643.80	74,747,765.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	85,499,455.00	145,454,400.90
210104	Урамшуулал	47,338,014.00	55,239,910.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>64,183,942.87</b>	<b>75,506,264.68</b>
210201	Тэтгэврийн даатгал	43,556,742.87	52,641,651.32
210202	Тэтгэмжийн даатгал	5,156,800.00	5,730,028.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,578,400.00	2,849,174.28
210204	Ажилгүйдлийн даатгал	2,578,400.00	2,849,174.28
210205	Эрүүл мэндийн даатгал	10,313,600.00	11,436,236.53
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>155,025,600.00</b>	<b>194,346,500.00</b>
210304	Байрны түрээс	155,025,600.00	194,346,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>41,418,234.60</b>	<b>38,201,862.00</b>
210401	Бичиг хэрэг	4,755,290.00	6,189,057.00
210402	Тээвэр, шатахуун	400,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,139,150.60	2,019,835.00

Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	34,123,794.00	29,992,970.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>390,000.00</b>	<b>15,800,000.00</b>
210604	Урсгал засвар	-	15,800,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,950,000.00</b>	-
210702	Дотоод томилолтын зардал	4,950,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>287,242,139.00</b>	<b>159,456,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	277,032,039.00	157,087,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,210,100.00	2,368,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	<b>58,634,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	55,722,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,912,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>76,752,370.74</b>	<b>151,562,402.15</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>71,507,241.00</b>	<b>19,361,200.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,267,200.00	19,361,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	52,240,041.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,245,129.74</b>	<b>132,201,202.15</b>
213303	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	400,709.74	28,678,668.55
213305	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	4,844,420.00	103,522,533.60
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>1,145,642,000.00</b>	<b>1,284,237,703.60</b>
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>125,123,000.00</b>	<b>106,239,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>125,123,000.00</b>	<b>106,239,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>125,123,000.00</b>	<b>106,239,800.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	125,123,000.00	106,239,800.00
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>125,123,000.00</b>	<b>106,239,800.00</b>
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(125,123,000.00)</b>	<b>(106,239,800.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>693,724,428.90</b>	<b>14,253,445,068.00</b>	<b>1,056,518,909.27</b>	<b>16,003,688,406.17</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	693,724,428.90	14,253,445,068.00	1,056,518,909.27	16,003,688,406.17
Тайлант үеийн үр дүн	-	-	126,506,682.70	126,506,682.70
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>693,724,428.90</b>	<b>14,253,445,068.00</b>	<b>1,183,025,591.97</b>	<b>16,130,195,088.87</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	693,724,428.90	14,253,445,068.00	1,183,025,591.97	16,130,195,088.87
Тайлант үеийн үр дүн	-	-	(38,232,561.47)	(38,232,561.47)
<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>693,724,428.90</b>	<b>14,253,445,068.00</b>	<b>1,144,793,030.50</b>	<b>16,091,962,527.40</b>

Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>1,200,032,100.00</b>	<b>1,156,993,531.45</b>	<b>43,038,568.55</b>	<b>96.4</b>
12	Татварын бус орлого	1,200,032,100.00	1,156,993,531.45	43,038,568.55	96.4
122	Тусламжийн орлого	1,200,032,100.00	1,156,993,531.45	43,038,568.55	96.4
122005	Төсвөөс санхүүжих	1,200,032,100.00	1,156,993,531.45	43,038,568.55	96.4
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,200,032,100.00</b>	<b>1,156,993,531.45</b>	<b>43,038,568.55</b>	<b>96.4</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,200,032,100.00</b>	<b>1,156,993,531.45</b>	<b>43,038,568.55</b>	<b>96.4</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,180,670,900.00</b>	<b>1,137,632,331.45</b>	<b>43,038,568.55</b>	<b>96.4</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>615,434,800.00</b>	<b>590,729,974.77</b>	<b>24,704,825.23</b>	<b>96</b>
210101	Үндсэн цалин	326,390,900.00	315,287,898.53	11,103,001.47	96.6
210102	Нэмэгдэл	80,260,400.00	74,747,765.34	5,512,634.66	93.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	150,684,800.00	145,454,400.90	5,230,399.10	96.5
210104	Урамшуулал	58,098,700.00	55,239,910.00	2,858,790.00	95.1
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>79,479,700.00</b>	<b>75,506,264.68</b>	<b>3,973,435.32</b>	<b>95</b>
210201	Тэтгэврийн даатгал	55,643,200.00	52,641,651.32	3,001,548.68	94.6
210202	Тэтгэмжийн даатгал	5,959,200.00	5,730,028.27	229,171.73	96.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,979,500.00	2,849,174.28	130,325.72	95.6
210204	Ажилгүйдлийн даатгал	2,979,500.00	2,849,174.28	130,325.72	95.6
210205	Эрүүл мэндийн даатгал	11,918,300.00	11,436,236.53	482,063.47	96
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>194,346,500.00</b>	<b>194,346,500.00</b>	<b>-</b>	<b>100</b>
210304	Байрны түрээс	194,346,500.00	194,346,500.00	-	100
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,134,300.00</b>	<b>18,351,092.00</b>	<b>1,783,208.00</b>	<b>91.1</b>
210401	Бичиг хэрэг	2,993,500.00	2,303,287.00	690,213.00	76.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,155,400.00	2,019,835.00	135,565.00	93.7
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,985,400.00	14,027,970.00	957,430.00	93.6
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>80,129,800.00</b>	<b>80,129,800.00</b>	<b>-</b>	<b>100</b>

Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	51,629,800.00	51,629,800.00	-	100
210602	Тавилга	28,500,000.00	28,500,000.00	-	100
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>132,511,500.00</b>	<b>119,934,400.00</b>	<b>12,577,100.00</b>	<b>90.5</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	117,565,500.00	117,565,500.00	-	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,977,100.00	-	4,977,100.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,968,900.00	2,368,900.00	7,600,000.00	23.8
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>58,634,300.00</b>	<b>58,634,300.00</b>	-	<b>100</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,722,300.00	55,722,300.00	-	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,912,000.00	2,912,000.00	-	100
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>19,361,200.00</b>	<b>19,361,200.00</b>	-	<b>100</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>19,361,200.00</b>	<b>19,361,200.00</b>	-	<b>100</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,361,200.00	19,361,200.00	-	100
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	36	36	-	100
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18	18	-	100
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14	-	100
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	100
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	18	18	-	100
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	15	15	-	100
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3	3	-	100

Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>204,805,303.60</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>204,805,303.60</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>204,805,303.60</b>
<b>1221</b>	<b>Хандив тусламж /дотоод/</b>	<b>204,805,303.60</b>
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	204,805,303.60
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	194,805,303.60
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>101,282,770.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>101,282,770.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>101,282,770.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>19,850,770.00</b>
210401	Бичиг хэрэг	3,885,770.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,965,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>23,790,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,990,000.00
210604	Урсгал засвар	15,800,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>57,642,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57,642,000.00
<b>4</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>103,522,533.60</b>
<b>5</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(103,522,533.60)</b>
<b>6</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>(103,522,533.60)</b>

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монголын уран зургийн галерей нь Монгол улсын нутаг дэвсгэрээс олдсон дүрслэх урлагийн бүтээлүүдийг цуглуулах, бүртгэх, хадгалах, судлан шинжлэх, сэргээн засварлах, олон нийтэд сурталчлах байнгын үйл ажиллагаатай ашгийн төлөө бус эрдэм шинжилгээний байгууллага болно.

“Монголын уран зургийн уламжлал, дэг жаягийн давтагдашгүй онцлогийг шингээсэн орчин үеийн бүтээлийг олон улсад таниулж, хүн амын оюун санаа, гоо зүйн хэрэгцээг хангахуйц бүтээлч орчин бүрдүүлэх, түүхийн дурсгалт бүтээлүүдийн хадгалалт хамгаалалтыг олон улсын жишигт хүргэх” чиг үүрэг бүхий Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 2024 оны 6 дугаар сард 6 дугаар зүйлийн 6.2.7-д “төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх”;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны А/112 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал, тайлбар, зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”
- Сангийн сайдын 2025 оны 240 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Соёлын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас Монголын уран зургийн галерейн 2025 оны III улирлын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 145.7 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	6,091.2	111,898.5	105,807.3
Бараа материал	186,117.6	222,342.8	36,225.2
Үндсэн хөрөнгө	15,937,986.3	15,960,256.8	22,270.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>16,130,195.1</b>	<b>16,294,498.1</b>	<b>164,303.0</b>
Өр төлбөр	-	202,535.6	202,535.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	693,724.4	693,724.4	-
Хуримтлагдсан үр дүн	1,183,025.6	1,144,793.0	(38,232.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	14,253,445.1	14,253,445.1	-
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>16,130,195.1</b>	<b>16,294,498.1</b>	<b>164,303.0</b>

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, хуримтлагдсан үр дүнгийн данснууд байна. Үүнд:

Тайлант онд авлага дансны үлдэгдэл 111,898.5 мянган төгрөг болсон нь үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг улсын төсөвт төвлөрүүлснээс авах авлага 103,522.5 мянган төгрөг, Соёл урлагийн газраас авах авлага 1,280.0 мянган төгрөг, ажилчидтай холбоотой авах 1,004.8 мянган төгрөгийн авлагуудыг бүртгэсэнтэй холбоотой байна. Мөн хувь хүмүүсээс авах 6,091.2 мянган төгрөгийн авлага нь өмнөх онуудад үүссэн, олон жилийн насжилттай авлага байна.

Бараа материал дансны үлдэгдэл 222,342.8 мянган төгрөг болж, 36,225.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант 124,778.7 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч данс бүртгэлд тусган, 88,553.5 мянган төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 15,960,256.8 мянган төгрөг болж 22,270.5 мянган төгрөгөөр өссөн нь Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас үнэ төлбөргүй өгсөн 3,120.0 мянган төгрөгийн компьютер хүлээн авч, тайлант онд 106,239.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан бөгөөд үүнтэй холбоотой байгуулсан элэгдлийн зардал болох 87,089.3 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцсоноос шалтгаалсан.

Өглөг дансны үлдэгдэл 202,535.6 мянган төгрөг болж өссөн нь үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг улсын төсөвт татан төвлөрүүлэн зарцуулах эрх олгоогүйн улмаас байгууллага болон хувь хүмүүст төлөх 103,522.5 мянган төгрөгийн, улсын төсвийн санхүүжилт дутуу олгогдсоноос үүссэн аудитын төлбөр, шуудан холбооны зардалд төлөх 5,499.5 мянган төгрөг, байр түрээслүүлэгч байгууллага болох Нийслэлийн Соёлын төв өргөө ОНӨААТҮГ нь тайлант онд түрээсийн төлбөрийг нэмэгдүүлснээс шалтгаалан төлөх 93,274.5

Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

мянган төгрөгийн, шүүхийн шийдвэрээр төлөх 239.1 мянган төгрөгийн цалингийн өглөгийг тус тус төлөөгүтэй холбоотой.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ дансны үлдэгдэл 1,144,793.0 мянган төгрөг болж 38,232.6 мянган төгрөгөөр буурсан байгаа нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан.

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа санхүүгийн, нярвын, санхөмрөгийн, архивын зэрэг нийт 37,970.0 мянган төгрөгийн өртөгтэй 6 программуудыг ашиглаж байгаа бөгөөд 7,648.0 мянган төгрөгийн хорогдуулга байгуулан санхүүгийн тайланд тусгасан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,096,210.8 мянган төгрөг, нийт зарлагыг 2,096,210.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, тогтмол зардал, хангамж, бараа материал, томилолтын зардлыг нийт 830,121.5 мянган төгрөгөөр бууруулж, 1,266,089.3 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй илүү тооцсон нь бууруулах шалтгаан болсон байна.

Тайлант онд төсвийн тодотголоор 66,057.2 мянган төгрөгөөр батлагдсан төсвийг бууруулсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,200,032.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 103,522.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,156,993.5 мянган төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 43,038.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71702 Соёл урлаг	1,200,032.1	1,156,993.5	43,038.6	96.4%
2	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	953,392.2	910,353.6	43,038.6	95.5%
3	80214 Уран бүтээлийн зардал	730.0	730.0	-	100.0%
4	80215 Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	1,500.0	1,500.0	-	100.0%
5	80219 Харуул, хамгаалалтын зардал	71,835.5	71,835.5	-	100.0%
6	81569 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	43,500.0	43,500.0	-	100.0%
7	81855 Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	129,074.4	129,074.4	-	100.0%

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

1. **Байгууллагуудын орон тооны цомхотголын талаар:** Эрх бүхий дээд байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу тухайн байгууллагын ажлын байрны чиг үүргийн шинжилгээ хийн бүтцийг шинэчлэн зохион байгуулан, Үзмэр харгалзагч-1, Эрдэм шинжилгээний ажилтан-1 нийт 2 орон тоог цомхотгосон.
2. **Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:** Тайлант онд бүтэц орон тоог 20 хүнээр төлөвлөн хоол, унааны хөнгөлөлтөд 150,684.8 мянган төгрөгийг баталсан, гүйцэтгэлээр дунджаар 18 бүтэц орон тоонд 145,454.4 мянган төгрөгийг зарцуулсан.
3. **Гадаад томилт, арга хэмжээний судалгааны талаар:** Тайлант онд гадаад албан томилт, арга хэмжээнд зардал гаргаагүй байна.
4. **Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны талаар:** Тайлант онд сургалт, семинар, хурал зөвлөгөөнд зориулж зардал гаргаагүй байна.
5. **Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн судалгааны талаар:** Тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ, төлбөрийн зардал гаргаагүй байна.
6. **Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардлын судалгааны талаар:** 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн Б/22 дугаар тушаалаар үзвэрийн танхимын үйлчилгээний ажилтныг халсныг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 181/ШШ2024/01335 дугаартай Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны цалинтай тэмцэх хэмжээний олговорт гаргуулах 2,310.0 мянган төгрөг гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлж бичилт хийлгэхийг шийдвэрлэсэн. Тайлант онд нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлсөн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 204,805.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. -

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Монголын уран зургийн галерей нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 407,061.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 12 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж баталсан байна. Гүйцэтгэлээр 407,061.6 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг байгуулан ажиллахдаа гүйцэтгэгчийг харьцуулалтын болон нээлттэй тендер сонгон шалгаруулах журмаар сонгон шалгаруулаагүй, шууд гэрээ байгуулан худалдан авалт хийж, гүйцэтгэлийг 100 хувиар тайлагнасан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монголын уран зургийн галерейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн галерейн үйл ажиллагааг сайжруулах дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, анхан шатны баримтын бүртгэл хөтлөлт, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Эс Жи Эм Ди-Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Бямбажаргал, аудитын шинжээч Ч.Ням-Очир, туслах ажилтан Э.Есүхэй нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын чанарын менежер О.Алтанцэцэг, аудитын менежер Б.Оюунцэцэг, захирал Д.Насанжаргал, Санхүүгийн аудитын газрын аудитор С.Билгүтэй, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,170,997.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 11,710.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монголын уран зургийн галерей нь албан томилолтоор ажиллуулсан байгууллагаас томилолтын зардал гаргаагүй, бусад байгууллагаас давхардуулж зардал олгоогүй, тэтгэвэрт гарахад нь олгосон нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг бусад тэтгэмжтэй давхардуулан олгоогүй мөн цахим дэлгүүрээс 7,990.0 мянган төгрөгийн компьютер худалдан авсан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 48,039.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 1 албан шаардлага өглөө.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 86 удаагийн 2,082,091.3 мянган төгрөгийн мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайланд онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлаагүй 48,039.9 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг нээлттэй тендер сонгон шалгаруулалтгүй шууд гэрээ байгуулан худалдан авсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална." гэж заасантай нийцээгүй байна.

#### **Шийдвэрлэсэн нь:**

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд зохих журмын дагуу өөрчлөлт оруулаагүй, мөн харуул хамгаалалтын үйлчилгээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтын журмаар шалгаруулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны III улирлын санхүүгийн тайланг хамруулж, 5 үндсэн данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 2,310.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулсан.

#### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны аудитаар илэрсэн 23,960.4 мянган төгрөгийн зөрчилд 2,079.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 14,289.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 6,091.2 мянган төгрөгийн 2 хариуцлага тооцуулах албан шаардлага, 1,500.0 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	2,079.4	2	2,079.4	100.0
Албан шаардлага	2	14,289.8	2	14,289.8	100.0
Хариуцлага тооцуулах албан шаардлага	2	6,091.2	2	6,091.2	100.0
Зөвлөмж	4	1,500.0	4	1,500.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>10</b>	<b>23,960.4</b>	<b>10</b>	<b>23,960.4</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Сангийн сайдын 2025 оны А/3 тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу санхүүгийн программ хангамжид тайлангийн маягт, заавартай тулган нийцүүлсэн эсэхийг үзэх
2. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн байгууллагын хэрэгцээнд ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгүүдийн үнийг шинэчлэн тогтоосон эсэхийг үзэх
3. Тайлант он болон өмнөх онуудад худалдан авсан 36,770.0 мянган төгрөгийн өртөгтэй AR, MR технологиор баяжуулсан программын ашиглалт, үр дүнг нарийвчлан анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,280.0 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

- Соёлын биет өвийг түгээх дэлгэрүүлэх зорилгоор бусдаар хийлгүүлэн, худалдан борлуулсан барааны орлого болох 1,280.0 мянган төгрөгийг бүртгэхдээ өөрийн орлого бууруулж бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2 -т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасантай тус тус нийцээгүй, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 33,105.5 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>2</sup> илэрсэнд, 18,545.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 14,550.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 33,105.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 21,395.5 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

#### 5.1.1 Бараа материалын данстай холбоотой асуудал

Байгууллагын бараа материалын үлдэгдэл, нөөц, тоо хэмжээнд үндэслэн төлөвлөөгүй 3 нэр төрлийн 1388 ширхэг 9,245.5 мянган төгрөгийн худалдан авалт хийж, бараа материалыг их хэмжээгээр бэлтгэн нөөцөлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-т "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" гэж заасантай тус тус нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шаардлагагүй бараа материалыг үндэслэлгүйгээр их хэмжээгээр бэлтгэн нөөцөлсөн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.1.2 Зардлын данстай холбоотой асуудал

Хувиараа үзэсгэлэн гаргаж байгаа зураачийн үзэсгэлэнд ирсэн хүмүүст зориулж катерингийн үйлчилгээний зардалд 4,800.0 мянган төгрөгийг олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-т "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;" гэж заасантай тус тус нийцээгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

### 5.1.3 Зардлын данстай холбоотой асуудал

Сан хөмрөгийн үзэсгэлэнгийн харуул хамгаалалтын зардалд 4,500.0 мянган төгрөгийг харилцагч байгууллагад төлж, төсөвт тусгагдаагүй ажлыг санхүүжүүлж, гэрээ дүгнэсэн акт, ажлын тайлангүй, гэрээний хэрэгжилтийг дүгнэж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж авсан ажилтан хариуцна.", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэж заасантай тус тус нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, төсөвт батлагдаагүй зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

## 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 5.2.1 Бараа материалтай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

Дундговь аймгийн 15 сум, аймгийн төвд уран зургийн галерейн салбар байгуулахад зориулж 14,550.0 мянган төгрөгийн үнэтэй 150 ширхэг жааз худалдан авсан, гэрээг байгууллагын нярав байгуулан бараа материалыг хүлээн авч байгаа нь ажил үүргийн хуваарийн дагуу тавих хяналт сул, үр ашиггүй зардал гаргах эрсдэлтэй байна. Эдгээр нь бараа материалын дансанд үлдэгдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-т "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэж заасантай тус тус нийцээгүй.

Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй
								Тоо	Дүн	
1	Соёлын биет өвийг түгээх дэлгэрүүлэх зорилгоор бусдаар хийлгүүлэн, худалдан борлуулсан барааны орлого болох 1,280.0 мянган төгрөгийг бүртгэхдээ өөрийн орлого бууруулж бүртгэсэн.	1	1,280.0	-	-	1	1,280.0	1	1,280.0	-
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,280.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1,280.0</b>	<b>1</b>	<b>1,280.0</b>	<b>-</b>

/мянган төгрөгөөр/

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж	
								Тоо	Дүн
1	Байгууллагын бараа материалын үлдэгдэл, нөөц, тоо хэмжээнд үндэслэн төлөвлөлийгээр 3 нэр төрлийн 1388 ширхэг 9,245.5 мянган төгрөгийн худалдан авалтыг хийж, шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн байна.	1	9,245.5	-	-	1	9,245.5	-	-
2	Хувиараа үзэсгэлэн гаргаж байгаа зураачийн үзэсгэлэнд ирсэн хүмүүст зориулж катерингийн үйлчилгээний зардалд 4,800.0 мянган төгрөгийг олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	4,800.0	-	-	1	4,800.0	-	-
3	Сан хөмрөгийн үзэсгэлэнгийн харуул хамгаалалтын зардалд 4,500.0 мянган төгрөгийг харилцагч байгууллагад төлж, төсөвт тусгагдаагүй ажлыг санхүүжүүлж, гэрээ дүгнэсэн акт, ажлын тайлангүй, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.	1	4,500.0	-	-	1	4,500.0	-	-
4	Дундговь аймгийн 15 сум, аймгийн төвд уран зургийн галерейн салбар байгуулахад зориулж 14,560.0 мянган	1	14,560.0	-	-	-	-	1	14,560.0

/мянган төгрөгөөр/

Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

төгрөгийн үнэтэй 150 ширхэг жааз худалдан авсан, гэрээг байгууллагын нярав байгуулан бараа материалыг хүлээн авч байгаа нь ажил үүргийн хуваарийн дагуу тавих хяналт сул, үр ашиггүй зардал гаргах эрсдэлтэй байна. Эдгээр нь бараа материалын дансанд үлдэгдэлтэй байна.	4	33,105.5	-	-	3	18,545.5	1	14,560.0
<b>Дүн</b>								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс		Зөвлөмж	
		Нийт зөрчил		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>						
1	Үр дүнд суурилсан санхүүжилтийн эх үүсвэрээс 48,039.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүй нээлттэй тендер сонгон шалгаруулалтгүй шууд гэрээ байгуулсан.	1	48,039.9	1	48,039.9	-	-
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>48,039.9</b>	<b>1</b>	<b>48,039.9</b>	<b>-</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 391/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/239/МА-СТА-ТЦЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын бараа материалын үлдэгдэл, нөөц, тоо хэмжээнд үндэслэн төлөвлөөгүй 3 нэр төрлийн 1388 ширхэг 9,245,500.00 (Есөн сая хоёр зуун дөчин таван мянга таван зуу) төгрөгийн худалдан авалт хийж, бараа материалыг их хэмжээгээр бэлтгэн нөөцөлсөн байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-т "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:", 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-т "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шаардлагагүй бараа материалыг үндэслэлгүйгээр их хэмжээгээр бэлтгэн нөөцөлдөг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын уран зургийн галерейн захирал (М.Отгончимэг), ерөнхий нягтлан бодогч (Г.Алтанчимэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Д.НАСАНЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-69.Docx

1526180850



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 392/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/239/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Хувиараа үзэсгэлэн гаргаж байгаа зураачийн үзэсгэлэнд ирсэн хүмүүст зориулж катерингийн үйлчилгээний зардалд 4,800,000.00 /Дөрвөн сая найман зуун мянга төгрөгийг олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-т "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын уран зургийн галерейн захирал (М.Отгончимэг), ерөнхий нягтлан бодогч (Г.Алтанчимэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Д.НАСАНЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 393/АД150122

Улаанбаатар хот

САГ-2026/239/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сан хөмрөгийн үзэсгэлэнгийн харуул хамгаалалтын зардалд 4,500,000.00 /Дөрвөн сая таван зуун мянга/ төгрөгийг харилцагч байгууллагад төлж, төсөвт тусгагдаагүй ажлыг санхүүжүүлж, гэрээ дүгнэсэн акт, ажлын тайлангүй, гэрээний хэрэгжилтийг дүгнэж ажиллаагүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж авсан ажилтан хариуцна", 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцээгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, төсөвт батлагдаагүй зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын уран зургийн галерейн захирал (М.Отгончимэг), ерөнхий нягтлан бодогч (Г.Алтанчимэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Д.НАСАНЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-69.Docx

1526180854



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 394/А0150122

Улаанбаатар хот

САГ - 2026/239/НА - СТА - ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Монголын уран зургийн галерейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайланд онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлаагүй 48,039,900.00 /Дөчин найман сая гучин есөн мянга есөн зуу/ төгрөгийн худалдан авах ажиллагааг нээлттэй тендер сонгон шалгаруулалтгүй шууд гэрээ байгуулан худалдан авсан.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд зохих журмын дагуу өөрчлөлт оруулаагүй, худалдан авах ажиллагааг сонгон шалгаруулалтын журмаар шалгаруулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын уран зургийн галерейн захирал (М.Отгончимэг), ерөнхий нягтлан бодогч (Г.Алтанчимэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН :

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
ЭС ЖИ ЭМ ДИ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Д.НАСАНЖАРГАЛ